

Философи, шашин судлал-ХІV
ЭКОЛОГИ МЭДЛЭГИЙН АНГИЛАЛЫН АСУУДАЛ

Г.Мэнд-Амар (Докторант)

МУИС. НШУС.

Философийн тэнхим

Түлхүүр үг: Экологи, эко төвт хандлага, хүн төвт хандлага, биологийн буюу сонгодог экологи, нийгмийн буюу хавсрага экологи

Гол агуулга: Энэхүү өгүүллээрээ экологийн тэдлэгийн ангиллын орчин үед баримталж буй чиглэлүүдийг тодруулж, түүнд анализ хийн, үнэлэлт дүгнэлт хийлээ. Хамгийн ерөнхий утгаар хүн төвт болон байгаль төвт хандлагуудыг ангилаж хүн төрөлхтний хөгжил дэвшил, байгалийн хуулиудын хоорондын холбоо хамаарлыг гаргаж тавьсан. Биологийн буюу сонгодог экологи, нийгмийн буюу хавсрага экологийн чиглэлүүдийн ангилалыг хийв. Байгаль хүрээлэн буй орчны хамгаалал дэлхий дахины тулгамдсан асуудал болохын хувьд нийгмийн амьдралын бүх хүрээ, ямар ажил мэрэгжилтэйгээс үл хамааран нийт хүн төрөлхтний асуудал гэдгийг тодруулж авч үзлээ.

Экологийн ухаан анх үүсэн төлөвшсөн үеэс биологийн шинжлэх ухааны бүрэлдхүүнд багтан амьд биет, хүрээлэн буй орчны хоорондын холбоо, хамаарлыг судлах биологийн ухааны нэгэн салбар болон хөгжиж иржээ. Нийлмэл, олон талын мэдлэгийн салбарыг хамарч байдгийн хувьд түүний ангиллын асуудал чухлаар тавигдаж байна. Шинжлэх ухааны судалгааны арга зүйн үйл явцад мэдлэгийн ангиллын асуудал онцгой байр суурь эзэлдэг. Энэхүү өгүүллээрээ экологи мэдлэгийн салбар, бусад шинжлэх ухаантай хэрхэн холбоотой болохыг ангилан авч үзлээ.

Экологи нь судлах зүйлийн хувьд нэн өргөн хүрээтэй, олон талыг хамарсан шинжлэх ухаан учраас түүнийг салбар ухаануудад ангилан бүлэглэх асуудал ч мөн л төдий хэмжээгээр нарийн нийлмэл байх нь ойлгомжтой.

Экологи нь хамгийн ерөнхий утгаар хүн ба байгалийн харилцааны талаарх үзлийг илэрхийлдэг. Иймд хүн төвт хандлага, байгаль төвт хандлага нь ерөнхий ангиллын утгыг илэрхийлэх болно. /Антропоцентризм, Экоцентризм/

Хүн төвт хандлага. “Энэ хандлагыг баримтлагчдынхаар хүн ба байгалийн хоорондох харьцааг хүн төрөлхтөн өөрөө төлөвшүүлэн тогтоох ажээ. Өөрөөр хэлбэл хүний хүсэл, зорилгод тохирсон тэрхүү зарчмыг мөрдлөг болгон хүн байгальтай харьцах учиртай. Энэ үзэл бодол, хандлагыг баримтлагчид байгалийн хуулийг эзэмшиж, түүнийг өөрийнхөө ашиг сонирхолд нийцүүлж, өөрийн оюун ухаан, нийгмийн байгууламж, техник, технологийн хүчин чадалд тулгуурлаж хүн төрөлхтөн байгалийн зүгээс нөлөөлж байдаг элдэв дарамтаас чөлөөлөгдөж чадсан хэмээн үздэг.

Харин хүрээлэн байгаа орчин бохирдож, доройтож буй зарим үзэгдэл бол зөвхөн аж ахуй эрхлэлтийг зохистой бус явуулсантай холбоотой хэмээн нотолно. Нийгмийн ба шинжлэх ухаан, техник, технологийн дэвшлийг байгалийн хуулиуд саатуулж чадахгүй, саад

тотгор учруулж болох аар саар асуудлыг, технологийг шинэчлэн сайжруулах замаар арилгаж болно гэж үздэг.”¹⁷⁰

Хүн төвт үзлийн дутагдал нь шинжлэх ухаан, техник технологийн дэвшлийн хүчээр байгалийг захирах хандлага хүчтэй болсон байна. Энэ нь хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй экологийн хямралын үндсийг бүрдүүлдэг байна. Антропологи шинж бүхий экологийн хямрал нь ихэнхдээ хүний үйл ажиллагааны сөрөг шинжээс гаралтай байдаг ба хүн төрөлхтний түүхэн динамик хөгжилд онцгой нөлөө үзүүлж байна. Өмнө нь ийм төрлийн экологийн хямрал нь хаагдмал шинж чанартай байсан бол орчин үеийн нөхцөлд тэдгээр нь өргөн цар хүрээтэй бөгөөд хүрээлэн буй орчны бохирдол, ургамлын бүрхүүл, амьтны аймаг, томоохон газар нутгийг аж ахуйн эргэлтэнд оруулсан зэргээс үүдэлтэй юм. Үүнээс үндэслэн урьд хожид байгаагүй үзэгдэл үйл явц бий болжээ. “Өнөө үед дэлхий нийтийн хэмжээнд хүлэмжийн хийн үзэгдэл, озоны цоорхой, уур амьсгалын дулаарал, ган, цөлжилт, байгалийн төрөл бүрийн зүйлийн хомсдол, хүчиллэг бороо, байгалийн гамшиг зэрэг байгаль орчны олон тулгамдсан асуудлууд нүүрлээд байна. Манай дэлхийд цаг тутам 3, хоногт 70 орчим зүйлийн амьтан, ургамал”¹⁷¹ бүр мөсөн устаж байна. Хүн амын тоо нэмэгдэж, түүнийг дагаад хүнс тэжээл, эд материалын хэрэгцээ, аж ахуйн үйл ажиллагааны цар хүрээ өссөн нь үүнийг гэрчилж байна.

Өрнөдийн ард түмэн байгальтай нэгдмэл байх үзлийг үгүйсгэж, хүн чадлынхаа хирээр байгалаас авч ашиглах ёстой, хүн бол байгалийн эзэн гэсэн үзлийг баримталж байна. Энэ талаар эко философич Дэвид Эбрам “Байгалийн гайхамшигт ертөнцийг хүний ертөнцөөс ч илүү хөгжингүй экологийн мэдрэмжтэй хүмүүс л ойлгож чадна. Гэвч шинжлэх ухаан техникийн хувьсгалын амжилтуудад ховсдуулсан Европын ард түмнүүд байгальтай нэгдмэл байх мэдрэхүйгээ алджээ. Одоо биднийг төрүүлсэн дэлхийг өөрийн сэрэл мэдэрхүйгүй болсон, хүн түүнийг дураараа эзэмших объект гэж тайлбарлаж байна. Бидний хүрээлэн байгаа хүчирхэг амьд хүчнүүдийг хүний үйлтэй харьцуулахад багахан ач холбогдолтой гэж тайлбарлаж байна.”¹⁷² Дэвид Эбрам цааш нь бидний хамаг гай зовлонгийн хамгийн гол эх сурвалж бол хүн байгалиас салсан явдал гэж үзээд, хүн зөвхөн байгалтай харилцаж байж л амьд бөгөөд мэдрэгч амьтан хэвээр үлдэнэ гэж үзжээ.

Хүн төвт үзлийн эсрэг үзэл буюу энэ дэлхийн амьдралын эх булаг бол байгаль орчин гэх дараах үзэл юм.

Эко төвт хандлага. “Хоёр дахь чиг хандлагыг баримтлагчид хүнийг байгалийн бүтээгдэхүүн, биологийн нэг зүйл, амьд махбодийн хувьд экологийн үндсэн хуулиудад захирагдаж, байгальтай харьцахдаа экологийн хуулиудын болзол, шаардлагыг хангах ёстой гэсэн үзлийг үндэс болгодог. Хүний нийгмийн хөгжил бол байгалийн түүхэн хөгжлийн нэг хэсэг учраас байгалийн шалгарал, түүний эргэлт буцалтгүй чанар, экологийн хүчин зүйлүүдийн үйлчлэх хэм хэмжээнд захирагдах ёстой. Хүнийг хүрээлэн байгаа орчинд гарч буй сөрөг үзэгдлүүдийн ихэнх нь хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй бөгөөд шим мандлын өөрөө өөрийгөө зохицуулах, сэргээх үйл ажиллагааг эвдсэнтэй холбоотой. Байгаль дахь түүхэн хөгжил эргэлт буцалтгүй байдаг тул түүнийг технологийн замаар дахин сэргээх

¹⁷⁰ Х.Тэрбиш, Я.Адъяа “Экологи” УБ., 2009. 8 дахь тал

¹⁷¹ Д.Базардорж. Ред. Экологи. УБ., 2003. 259 дэх тал

¹⁷² Мантатов В.В. Стратегия разума: экологическая этика и устойчивое развитие. Улан-Удэ., 2000. с 29

боломжгүй. Хүн төрөлхтний хөгжил байгалийн хуулиудын үйлчлэлээс хамаарч, түүгээр зохицуулагдаж байдаг хэмээн тэд үздэг. Мөн биосферийн тогтвортой хөгжлийг шийдвэрлэгч нь экологийн хүчин зүйлүүд гэж хүлээн зөвшөөрдөг. Энэ хандлагыг биологичид, экологичид, байгаль судлаачид, сонирхогчдын хүрээнд баримталдаг.”¹⁷³

Хүний нийгмийн хөгжлийн эхэн үеүдэд хүн төрөлхтөн байгалийн түүхэн хөгжлийн нэгэн хэсэг болж, байгаль орчны унаган төрх байдлыг эвдэхгүйгээр орчинд нь дасан зохицож амьдарч иржээ.

“Экологийн судлах объектийн гол зүйл нь төрөл бүрийн салбарын мэргэжилтнүүдээс түүнийг судлах асуудалд анхаарлаа хандуулдаг. Ихэнхи хүмүүсийн амьдралд түүнийг судлахын чухал зэрэг нь тухайн шинжлэх ухааныг бусад шинжлэх ухаанаас тэргүүн байр эзэлдэг гэдгийг тодорхойлсон энэхүү ер бусын нарийн нандин зүйл олон талтай физик хүрээлэлтэйгээр нэгдсэн нь экологийн шинжлэх ухааныг хамгийн өргөн хүрээтэй асуудлыг хамардаг шинжлэх ухаан болгон өөрчлөв. Ийм олон янзын үзэгдлүүдэд хамгийн олон тоогоор янз бүрийн түвшинд хамгийн олон янзын тайлбар хайж олдог ийм шинжлэх ухаан бараг үгүй.”¹⁷⁴ Ийм үзлийн үүднээс орчин үед экологийн шинжлэх ухааныг байгалийн болон хүний үйл ажиллагааг гол болгон ангилдаг. Байгалийн утгыг илэрхийлэх утга нь биологийн буюу сонгодог экологи болон хүний үйл ажиллагааг гол болгодог ангилал нь нийгмийн буюу хавсрага экологи болно.

Биологийн буюу сонгодог экологи. Амьд бие махбодийн амьдралын онцлог бол байгалийн тодорхой нэг орчин нөхцөлд дасан зохицож, гадаад орчны нөлөөнд бүлгийн зохион байгуулалтад орох, хооллох ундлах, үр удмаа үлдээх зэргээр нэг нэгэнтэйгээ холбоо хамааралтай амьдардаг. Ийм гадаад орчны тодорхой нөхцөлийн хүрээнд амьд бие махбодийн хамсан амьдарч буй бүтэц, зохион байгуулалтын популяц, бүлгэмдэл, экосистем /биогеоценоз/, биосфер гэсэн үндсэн түвшингүүд манай дэлхий дээр бодитойгоор оршин тогтнож байна. Тус бүрийг нь тодорхойлон доор тайлбар хийв.¹⁷⁵

Популяци, бүлгэмдэл, экосистем, биосфер нь амьдралын бүтэц, зохион байгуулалтын макро түвшинд мөн чанар, зүй тогтлыг авч үзэж судалдаг. Иймд эдгээр нь экологийн ухааны

¹⁷³ Х.Тэрбиш, Я.Адъяа “Экологи” УБ., 2009. 9 дэх тал

¹⁷⁴ Всемирная энциклопедия: Философия. 2001. с 1251

¹⁷⁵ Популяци: Нэгдмэл нэг газар нутагт хамт оршин амьдарч, бие биедээ байнга харилцан нөлөөлдөг, хүрээлэн буй орчны нөхцлийн өөрчлөлтийг тэсвэрлэн тоо толгойн байдлаа удаан хугацаанд тогтмол барих чадвар бүхий нэг зүйлийн бүлэг бодгалиудыг популяци гэнэ. Латин хэлний популюс-ард түмэн, хүн ам гэсэн утгатай үг юм.

* Бүлгэмдэл: Биоценоз-өөр хоорондоо ба хүрээлэн буй гадаад орчинтойгоо амьдралын тодорхой харьцаагаар холболдон зохилдсон, ус ба хуурай газрын нэг хэсэгт амьдарч буй ургамал, амьтан, бичил бие мах бодийн нэгдлийг хэлнэ. Өөрөөр зүйлийн популяциудын нэгдлийг бүлгэмдэл гэнэ.

* Экосистем- “Эко” гэдэг нь монгол хэлээр орчин гэсэн үг бөгөөд, орчин нь угамал, амьтан тэдгээрийн бүл бүлгэмдэл орших орчны харьцаа холбоог илэрхийлнэ. “Систем”-Тогтолцоо /грек хэлний systema-бүхэл, нэгдэл гэсэн утгатай үг/, Бүхлийг бүрэлдүүлэгч, харилцан холбогдсон элементүүдийн эмх цэгцлэгдсэн олног. Үйлдлийн залгамжит шинжтэй холбоо бүхий хэсгүүдийн байнгын шинжтэй зохистой байрлалыг тогтоосон эмх цэгцлэгдсэн байдал.

* Орчин гэдэг нь нөхцөл байдлын хэмжээгээрээ бие биеээсээ хамааран орших биологийн объектууд юм. Тухайлбал Орхон, Сэлэнгийн сав газрын экосистемийн байдалд өгөх үнэлгээ төсөл юм. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. ШУА. V боть. УБ., 2008. 2774-р тал

* Биосфер-/грек bios-амьд, sphaira- бөмбөрцөг, хүрээ гэсэн үг/ Амьд организмын орших талбар. Түүнд атмосферийн доод, гидосфер бүхлээрээ, литосферийн дээд үеүүд багтах ба дэлхийн хамгийн том экосистем юм. Тэрээ юмс үзэгдлийн биотик эргэлт, солилцоог буюу байнгын амьд эргэх холбоог илэрхийлнэ. Уг нэр томъёог анх нэрт эрдэмтэн Вернадский хэрэглэсэн.

сонгодог салбарын судлагдахуунууд юм. “Харин экологийн шинжлэх ухааны эрчимтэй хөгжлийнх нь үе ХХ зууны эхээр өрнөжээ. 1912 онд Брюссель хотноо хуралдсан дэлхийн ботаникийн III конгрессээс экологийн шинжлэх ухааныг аутоэкологи буюу бодгалийн экологи, синоэкологи буюу бүлгэмдлийн экологи гэж хоёр том салбар болгосон нь экологийн шинжлэх ухааны цаашдын хөгжилд чухал хувь нэмэр болсон гэж үздэг.”¹⁷⁶

Орчин үед экологи нь нарийн, нийлмэл шинжлэх ухаан болсон бөгөөд судлах зүйлийн шинж чанар, төлөв байдлыг нь тодруулан дараах үндсэн салбарт ангилна. Үүнд:

1. Бодгалийн экологи буюу аутоэкологи: Амьдрах орчин, экологийн хүчин зүйлийн шинж чанар, тэдгээрийн амьд биед үйлчлэх үндсэн зүй тогтол, хүчин зүйлийн үйлчлэлд амьд биесийн дасан зохицох онцлогийг судална.
2. Популяцийн экологи буюу демэкологи: Нэг зүйлийн бодгалиуд /популяцийн хүрээнд/ ба хүрээлэн буй орчны харилцан холбооны мөн чанар, популяци оршин тогтонох зүй тогтлыг судална.
3. Экосистемийн тухай сургаал буюу синэкологи: Янз бүрийн зүйл организмууд /биоценозын хүрээнд/, тэдний амьдрах орчны хоорондын харилцан холбооны мөн чанар, зүй тогтлыг судална. Экосистемийн бүтэц бүрэлдэхүүн, үндсэн үйл ажиллагаа, бодис, эрчим хүчний хуваарилалт, шилжилт биологийн бүтээгдэхүүний үүсч бүрэлдэх онцлогийг судлах нь экологийн ухааны энэ салбарын үндсэн зорилтуудын нэг мөн.
4. Биосферийн тухай сургаал буюу даян дэлхийн экологи: Манай дэлхийн агаар мандал, усан мандал үүсэн бүрэлдэхэд амьд бие махбодын гүйцэтгэх үүрэг, биосферийн хүрээнд явж буй амьдралын мөн чанар, зүй тогтлыг цогцолбороор судлана.¹⁷⁷

Биологийн буюу сонгодог экологийн салбарт макро түвшний судлагдахуунаас гадна микро түвшинд амьд ба амьгүй гэсэн хоёр хэсэгт хуваан авч судалдаг. Түүнчлэн органик болон органик биш биологийн шинжлэх ухааны судлагдахуун ч гэж нэрлэдэг.

Амьд бие махбодийн ямар бүлгийг судалж байгаагаас нь хамаарч ургамлын экологи, амьтны экологи, бичил биетний экологи, ойн экологи, хүний экологи гэх мэтээр ангилна. Улмаар шувууны экологи, мөлхөгчдийн экологи, загасны экологи, шавьжийн экологи гэх мэтээр ангилал зүйн тодорхой бүлэг тус бүрээр цааш салбарлана. Жишээлбэл: Амьд амьтдын биеийн бүтэц, үйл ажиллагаа, үүрэг дээр суурилсан төрлүүдийн оршин тогтнох явцыг судалж, тэдгээр амьтад хооллох, үр удмаа үлдээх, сүргээр амьдрах зэрэг орчинтойгоо хэрхэн нарийн харилцан холбоотой гэдгийг нээн харуулж, тэдгээрийн онцгой харилцааг тогтоосноор экологи хувьслын шинжилгээ нь судалгааны багагүй ач холбогдол болох юм.

Амьдрах орчны иж бүрдэл, шинж чанарыг харгалзан хуурай газрын экологи, далай тэнгисийн экологи, цэнгэг усны экологи, хөрсний экологи, мөн орон зай, цаг хугацааны хамаарлаар нь түүхэн хувьсах хөгжлийн экологи, палеоэкологи хэмээн ангилдаг.¹⁷⁸

¹⁷⁶ Х.Мөнхбаяр, Мөнхбаатар “Хялбаршуулсан экологи” УБ., 2006. 4 дэх талд

¹⁷⁷ Х.Тэрбиш, Я.Адъяа “Экологи” УБ., 2009. 6 дахь тал

¹⁷⁸ Мөн тэнд. 6 дахь тал

Органик, органик биш аль нь ч организмуудын хэлбэр бүрт нэлээд их ач холбогдолтой байдаг. Юу гэвэл тэдгээр нь өөртөө дасан зохицуулах чадвартай байдаг. Органик биш оршин тогтнох нөхцөлд нэгдүгээрт: тэдгээрийн оршин тогтнох газар нутгийн физик болон химийн чанар бүхий цаг агаар, гэрэл, дулаан, чийг, агаарын цахилгаан гүйдэл гэх мэт багтана, хоёрдугаарт: органик биш хоол хүнс, ус болон хөрсний бүтэц гэх мэтийг хамааруулдаг. Органик оршин тогтнох нөхцөлд түүний бүхий хэлхээ холбоонд багтдаг, тэдгээрийн ихэнх нь ашиг тусаа өгдөг ба хор хөнөөл учруулдаг бусад бүх үлдсэн организмуудын ерөнхий харилцааг авч үздэг. Экологийн судлах зүйлийг ингэж хангалттай нарийн тодорхойлсон нь түүнийг өргөнөөр хүлээн зөвшөөрүүлэхэд нөлөөлсөн, яагаад гэвэл организмуудын харилцан хоорондын холбоо болон тэдний амьдрах орчны гадаад онцлогуудад анхаарлыг хандуулсан болно. Органик болон органик биш организмууд нь хоорондоо хэлхээ холбоо бүхий, зүй тогтолтой оршихуйнууд юм. Органик биш нөхцөл нь аль ч органик организмын оршин тогтнох нөхцөлийг бүрэлдүүлж байдаг. Газар нутгийн /физик болон хими/ цаг агаар гэрэл дулаан, чийг, агаар, хоол хүнс, ус болон хөрсний бүтэц, хоол хүнс нь бүгд органик зүйлийн оршин тогтнох орчныг нөхцөлдүүлж байдаг. Тийм ч учраас байгаль амьдралын мөн чанарыг урдаас өөрөө төлөвлөсөн байдаг гэсэн үг оргүй хоосон биш юм.

Экологи нь байгаль шинжлэлийн бусад шинжлэх ухаануудын судалгааны хэрэгсэл болдог онцлогтой. Ийм шинжлэх ухаануудад биологийн ба /физиологи, генетик, биофизик/, биологийн бус шинжлэх ухаан /физикийн, химийн, геологийн, газарзүйн, математикийн экологи зэрэг/ багтдаг. Жишээлбэл: Математикийн задлан шинжлэл ба тооцоолон бодох аргуудыг өргөн хэрэглэн экологийн харилцан холбоо цогц нэгдэл, хөгжлийн үе шат түвшин зэрэгт үнэлэлт дүгнэлт өгөх нь экологийн цаашдын хөгжилд онолын үндэс болсон.

“Өнөө үед хүн төрөлхтөн өөрийн амьдрал үйл ажиллагааныхаа хүрээг үлэмж тэлж, зөвхөн дэлхий орчмын төдийгүй, алс холын сансрын огторгуйд хүртэл хүрэх болсон билээ. Иймд глобал, сансрын, анагаах ухааны экологи шинжлэх ухааны салбар ойлголтууд бий болж хөгжих боллоо. Хүн ба техник нь байгаль орчинтой, үйлдвэрлэлийн орчинтой харьцах үйл ажиллагааг ялган авч үзэх нь чухал бөгөөд эхнийх нь экологийн асуудал болдог бол хоёр дахь нь гол төлөв хөдөлмөр хамгааллын /дуу шуугиан, халаалт, гэрэлтүүлэг г.м./ асуудал болдог онцлогтой.”¹⁷⁹ Гэвч эдгээр нь хоорондоо уялдаа холбоо бүхий үзэгдлүүд юм. Тухайлбал хүн төрөлхтний түүхийн эрт дээр цагт үйлдвэрлэлийн хөгжил байгалийн нөхцөлөөс ихээхэн хэмжээгээр шалтгаалж байв. Тэр үед байгаль нь хоол ундны байгалийн зорь, хөдөлмөрийн багаж зэвсгийн байгалийн /сан/, /шидэх цохиход чулуу гэх мэт/ үйлдвэрлэлийн орчны анхны шинж тэмдгүүд илэрч байв. Үйлдвэрлэлийн орчин үүссэнээр ажил хөдөлмөр хийх, хөгжил дэвшлийн эхлэлийг тавьжээ. Үйлдвэрлэлийн орчны үүсэл нь байгалийн унаган орчин тухайлбал, газар тариалан, мал аж ахуй, ан гөрөө зэрэг аж ахуйн үйл ажиллагааны эхлэлүүд байв.

Шинжлэх ухааны экологи. Экологийн хандлага нь экологийн системд хүн төрөлхтөн түүхэн хугацаанд /уран барилга, байгалийн хөшөө дурсгал зэрэг/-ийг бүтээсэн соёлын орчны янз бүрийн элементүүдийг сэргээн босгож хамгаалах арга замыг хайдаг экологийн соёл, шинжлэх ухааны шинжилгээ судалгааны төвүүд, боловсон хүчин, бүс нутаг ба нийт үндэсний сүлжээн дэх шинжилгээ судалгааны байгууллага, хүрээлэн, мэдээллийн хэрэгсэл,

¹⁷⁹ Т.Сэнгэдорж. “Экологийн эрх зүй”. УБ., 2001. 6 дахь тал

санхүүгийн, шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн бүтэц газар зүйн байрлалыг шинжлэн судалдаг шинжлэх ухааны экологи зэргийг гаргаж иржээ.¹⁸⁰

Нийгмийн буюу хавсрага экологи.

“Нийгмийн экологи” нь хүний хамтын нийгэмлэгүүд болон хүрээлэн буй газар зүй, орон зайн, нийгэм соёлын орчны харьцаа, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны, хүрээлэн буй орчны бүтэц байдалд шууд, шууд бишээр нөлөөлөх, антропологийн ялангуяа хотожсон газар нутаг, бусад экологийн хүчин зүйлс хүний бие, сэтгэл зүй, эрүүл мэнд, хүний хөгжлийн генийн сан зэрэгт нөлөөлөх зэргийг судалдаг шинжлэх ухааны салбар юм.

Америкийн эрдэмтэн Д.П.Март ХІХ зуунд хүн байгалийн тэнцвэрийг сүйтгэсэн олон жишээг шинжлэн дүгнээд байгаль хамгаалах хөтөлбөрийг боловсруулжээ. ХХ зууны Францын газар зүйч П.Видадь. де ла Блаш, Ж.Брон, Э.Мартонн нар газар зүйн сургуультай үзлийг хөгжүүлжээ. Түүний судлах зүйл нь гариг ертөнц дээр болж байгаа хэсэг үзэгдлийг судлах ба тэдгээр нь хүний үйл ажиллагаатай хэрхэн холбоотой гэдгийг судалж байв.

ХХ зуунд Голланд, Францын газар зүйн сургуулийн төлөөлөгчид Л.Февр, И.П.Герасимов нарын зохиол бүтээлүүдэд газар зүй, нутаг дэвсгэрт хүнээс үзүүлэх үйлдэл, үр нөлөө, түүний үйл ажиллагаа нийгмийн орон зайд илрэлээ олох зэргийг шинжлэн судалсан байна. Эдгээр сэтгэгчдийн үзэл нь нийгмийн экологийн эхлэлийг тавьжээ.

Байгаль хүрээлэн буй орчны хамгаалал дэлхий дахины тулгамдсан асуудал болохын хувьд нийгмийн амьдралын бүх хүрээ, ямар ажил мэрэгжилтэйгээс үл хамааран нийт хүн төрөлхтний оролцоог шаардах болжээ. Энэхүү эрэлт хэрэгцээнээс үүдэн байгаль ба хүний нийгэм, хүн төрөлхтний эрхэлж буй төрөл бүрийн үйлдвэрлэл, аж ахуйн салбар хоорондын харилцан нөлөөлөл, хамаарлыг судлах зорилготой экологийн олон салбар ухаан үүсэж хөгжсөн юм. Эдгээрийг ерөнхийд нь хавсрага буюу нийгмийн экологийн салбарууд хэмээн авч үздэгийг Х.Тэрбиш, Я.Адъяа нар онцолжээ.

Сүүлийн үед шинжлэх ухааны бүх салбар экологичлогдож байна гэсэн үзэл нэлээд түгээмэл байна. Хавсрага экологийн голлох чиглэлүүдийг дурдвал:

Хөдөө аж ахуйн экологи – Энэ нь экологи хөрсийг бохирдуулахгүй, үржил шимийг бууруулахгүйгээр экологийн хувьд цэвэр хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн гаргаж авах онол арга зүйн үндсийг боловсруулдаг.

Үйлдвэрийн /инженерийн/ экологи - Хаягдлын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тогтоох, технологи, цэвэрлэх байгууламжийг боловсронгуй болгож сөрөг нөлөөг бууруулах боломж нөхцөлийг судалдаг. “Экологийн глобал асуудал үүссэн нь техникийн дэвшлийн хувьд аж үйлдвэржилтийн олон салаа үзүүлэлтүүдтэй шинжлэх ухааны хөгжлийн хувьд сциентизмын үнэлэмж өндөрссөнтэй, нийгэм соёлын хувьд нийтийн соёлын элементүүд түгэн тархаж, хэрэглээний төрөл, хүрээ өргөссөнтэй, нийгмийн динамикийн

¹⁸⁰ *Философский энциклопедический словарь. М., 1989. с 757*

хувьд социаль мобил шинж ихсэж, социаль үйлдэл үйл ажиллагааны хувьд хүн төрөлхтөн улам бүр глобалчлагдах болсонтой холбоотой байна.”¹⁸¹

Хот суурин газрын экологи – Хот суурин газарт ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах асуудлыг судална.

Анагаах ухааны экологи – Орчны бохирдол, хүн амын зан үйлээс үүдэлтэй халдварт ба халдварт бус өвчлөлтийг судалж, түүнээс урдчилан сэргийлэх, эмчлэх арга замыг тодорхойлон тогтооно. Хүн амын эрүүл мэндийн үзүүлэлт бол тухайн нутгийн амьдрах орчны төлөв байдлыг дээд зэргээр тусган харуулдаг үзүүлэлт болж өгдөг.

Химийн экологи – Хүнсний бүтээгдхүүн, ус, агаар, хөрсөнд байгаа хорт ба бохирдуулагч бодисыг илрүүлэх, ахуйн ба үйлдвэрээс ялгарах хий, шингэн, хатуу хог хаягдлыг цэвэрлэх, хог хаягдлын хэмжээг багасгах технологийг боловсруулан нэвтрүүлэх асуудлыг судална.

Байгаль орчны эдийн засаг – Байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах, хамгаалахтай холбогдсон эдийн засгийн үндэслэлийг боловсруулдаг. Тухайлбал, байгалийн нөөц баялгийн /газрын тос, ой мод, ус г.м/ үнэ өртөг, байгаль бохирдуулагчдад оногдуулах торгуулийн хэмжээг тооцоолон тогтоох зэрэг орно. Экологийн системийн зарчмууд нь байгалийг эзэмших төдийгүй эко мандлыг сэргээн босгох болон хамгаалахад зарцуулах тооцоондоо ашиг орлого, үйлдвэржилтийн шалгуур төдийгүй мөн техникийн шинэчлэлт экологийн үндэслэл харгалзан байгалийг зөв зохистой ашиглахад болон аж үйлдвэрийн төлөвлөлтөд экологийн хяналт тавьдаг экологийн эдийн засагт ч өөрийн илрэлээ олж байна. Орчин үеийн бизнесийн шинэ эринд “иргэний нийгэм, засгийн газар, бизнесийн байгууллага бүгд хүгээлэн буй орчинд хохирол учруулахгүйгээр ажиллах хөгжлийн шинэ зорилго чиглэл”¹⁸² бүхий экологийн этикийн салбар болон хөгжиж байна.

Экологийн эрх зүй – Экологи, байгаль хамгаалах хууль, эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх, боловсронгуй болгох, хэрэгжүүлэх, түүнд нийгмийн харилцаа хэрхэн холбогдох асуудлыг судалдаг ухаан юм. “Экологийн эрх зүй бол байгалийн тэнцвэрт байдлыг хангах, байгаль нийгмийн харилцан үйлчлэлийн явцад хүн байгальтай харьцах, түүний нөөц баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах журам, нөхцөлийг зохицуулсан хууль тогтоомжийн баазад тулгуурлан бүрэлдэн тогтох бөгөөд тэдгээр хууль, эрх зүйн бусад актууд нь уг эрх зүйн сурвалж болно.”¹⁸³

Экологийн боловсрол – “Экологийн боловсрол гэдэг нь байгаль орчны үндсэн асуудлыг танин мэдэж, экосистемийн хөдлөл зүйг судалж, ирээдүйн байгалийн хувьсал, өөрчлөлт, хэтийн төлөвийг тогтоон түүнд тохирсон зүй зохистой үйл ажиллагаа явуулах мэдлэг чадвар, дадлын цогц бөгөөд”¹⁸⁴ боловсролын аль ч төвшинд экологийн баримжаатай мэдлэг чадвар олгох явдал нэлээд түгээмэл болоод байна.

¹⁸¹ Б.Пүрэвсүрэн. Экологийн глобал асуудал бол нийгэм-техникийн философийн судлагдахуун болох нь. МУИС. Философи, шашин судлал IV. УБ., 2006. №253. 208 дахь тал

¹⁸² Environmental sciense. A study of interrelationships. Eight edition. USA. New York. 2002. p 25

¹⁸³ Т.Сэнгэдорж. “Экологийн эрх зүй”. УБ., 2001. 22 дахь тал

¹⁸⁴ М.Золзаяа “Экологийн ёс зүй”. Мэргэжлийн ба хэрэглээний ёс зүй., УБ. 2012, 369-370 дахь тал

Аливаа шинжлэх ухааны судалгааны арга зүйн үйл явцад мэдлэгийн ангиллын асуудал онцгой байр суурь эзэлдэг. Экологийн судлах зүйлийн олон салбар шинжүүдийг тодорхойлсноор, салбар шинжлэх ухаануудын хоорондох холбоо харилцааг илрүүлэх, завсрын шинжтэй бусад харилцааг зохицуулах олон эерэг талтай. Мөн хүрээлэн буй орчин, ой, хээр тал, ус, бэлчээр, үйлдвэрлэл, уул уурхай зэрэг байгаль, нийгэм, хүний харилцааны болон байгалийн өөрийн зүй тогтолт үйл явцын судалгаа шинжилгээнд хэрэглэх чухал ач холбогдолтой болно.

НОМ ЗҮЙ

4. Д.Базардорж Ред. Экологи. УБ., 2003
5. Данило Ж.Маркович “Социальная экология” М., 1997
6. Мантатов В.В. Стратегия разума: экологическая этика и устойчивое развитие. Улан-Удэ., 2000
7. Х.Мөнхбаяр, Мөнхбаатар “Хялбаршуулсан экологи” УБ., 2006
8. Т.Сэнгэдорж. “Экологийн эрх зүй”. УБ., 2001
9. С.Түмэнгэрэл. Нийгмийн ухааны зарим нэр томъёоны тайлбар. УБ., 2002
10. Х.Тэрбиш, Я.Адъяа “Экологи” УБ., 2009
11. Всемирная энциклопедия: Философия. Харвест., 2001
12. Environmental sciense. A study of interrelationships. Eight edition. USA. New York. 2002
13. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. ШУА. V боть. УБ., 2008
14. Мэргэжлийн ба хэрэглээний ёс зүй. УБ., 2012
15. Философский энциклопедический словарь. М., 1989

SUMMARY

In this article, the modern trends and of category of ecological knowledge are determined as well as I gave my own assessment. Generally, I introduced the relationship between human development and the laws of nature as having classified the eco-centrism and the anthropocentrism.